

ЯЛТЫН БАГА ХУРАЛ: ЦЭРЭГ-СТРАТЕГИЙН АЧ ХОЛБОГДОЛ*Л.Моломжамц**

Одоогоос жарны тэртээ дэлхийн 2 дугаар дайны төгсгөл, үр дагаварт төдийгүй түүний дараах дэлхийн улс түмний хөгжил тогтнол, ялангуяа хүчний харьцааны болон цэрэг-улс төрийн эвсэл холбоодын дүр төрх, үйл ажиллагаанд гүн гүнзгий ул мөр үлдээсэн түүхэн үйл явдлын нэг нь 1945 оны эхээр болсон гурван их гүрний төрийн тэргүүнүүдийн дээд хэмжээний уулзалт-Ялтын /Крымын/ бага хурал юм.

Өмнөх илтгэгчдийн хэлсэнчлэн энэ бага хурал БНМАУ-ын тусгаар тогтнол, бүрэн эрхт статус-квог Сталины санал “шахалтаар” хэлэлцэж тогтоосон нь түүхэн үнэн бөгөөд ийм ойлголт үнэмшил монголчуудад хэзээд ч мартагдахааргүй, үе дамжин хоногшин үлдсэн билээ. Иймээс тус бага хурлын түүхт ойд Монголын өнөөгийн олон нийт, ялангуяа ахмадууд бусдаас хүндэтгэлтэй хандахдаа тэр үеийн холбоотон байсан бөгөөд орчин үеийн түнш гурван гүрний ард түмэнд, өнөөдрийн энэ арга хэмжээг санаачлагчдад гүнээ талархаж байгаа гэдэгт эргэлзэхгүй байна.

Хэдийгээр урьд өмнө нь үзэгдээгүй хөнөөлт дайны хүнд хүчрийг өөрсдийн биеэр амсаагүй ч Зөвлөлт Оросын сургуультай, Монголын өнөөгийн ахмад үе, энх цагийн ахмад дайчид Ялтын бага хурлыг дэлхийн 2 дугаар дайны эцсээрх ЗХУ-ын дипломатын “оргил нь” гэж үзэж үнэлж заншсаныг гайхах, адлахын хэрэггүй биз ээ. Энэ нь БНМАУ дайны эхний өдрөөс эцсийг хүртэл нь ЗХУ-ын хамгийн ойрын үнэнч холбоотон нь байж, манай ахмад үеийнхэн өөрсдийн амь амьдралыг юман чинээ бодохгүй харин Зөвлөлтийн ард түмэн, улаан армид бүх л чадал, чинээгээрээ тусалж байсны зах зухыг тэр үеийн хүүхдүүд бид гадарладаг, мөн бидний ахмадууд цагтаа “Монгол, Зөвлөлтийн ах дүүгийн найрамдалд” үнэнч байх үзэл хүмүүжилд мартахын аргагүй “чанагдаж”, бас үр шимийг нь ч хөхөж хөлжсөн гэж боддогтой дээрх нь бас холбоотой юм.

Эдүгээ 60 жилийн ой нь тохиож буй Ялтын бага хурлын тухай гадаад, дотоодын нэртэй түүхчид, дипломатчид маш их ярьж бичсэн байдаг нь түүний цар хүрээ, ач холбогдлын бодит илрэл. Энд ч утга төгөлдөр хоёр сайхан илтгэл тавигдлаа гэж бодож байна, миний хувьд бол энэ сэдвээр хичнээн хичээсэн ч эргэн нэхсэн шинэ юм хэлж чадахааргүйд хүлцэл өчиг. Харин “Ялтын” хэмээн нэрлэгддэг дэлхийн дэг журам, олон улс тогтнолын систем 45 жилийн туршид манай гаригийн

*Л.Моломжамц - БХЯ-ны дэргэдэх Стратегийн судалгааны хүрээлэнгийн захирал, профессор

улс төрийн бодлого, стратегийн хүчний хуваарь, харьцааг тодорхойлсоор ирсэний гэрч нь миний үеийнхэн мөн. Хуучин ЗХУ задарч, хоёр Герман нэгдэж, Зүүн ба Төв Европ, тэрчлэн Азийн зарим оронд ардчилсан хувьсгал гарч, одоо хэрэв Солонгосын хуваагдмал байдал, Орос-Японы харилцаанд үе үе газар нутгийн яриа маргаан үүсэх нь бийг эс тооцвол Ялтын системээс юу ч үлдэлгүй зөвхөн түүх, түүхэн сургамж болон хоцров.

Энэ өнцгөөс тухайн үеийн цэрэг-улс төрийн байдал, фашизмын эсрэг холбоотон гүрнүүдийн цэрэг-стратегийн ажиллагаанд шууд хамаарах ганц нэг асуудлыг маш товч хөндөхийг хичээе.

1. Ялтын бага хурлын өмнөх цэрэг-улс төрийн байдлыг авч үзэхдээ юуны өмнө ЗХУ /түүний холбоотнууд ч ялгаагүй/ дайныг бүүр эхнээс нь дипломатын болон цэргийн гэсэн хоёр фронтод явуулж байсныг, 1940 оны сүүлийн хагасыг хүртэл үүний хамгийн хүнд асуудал нь холбоотны цэрэг-улс төрийн харилцаа, фронт дахь цэргийн харилцан ажиллагаа байсан юм билээ гэдгийг сануулахыг хүсч байна. Дипломатын фронт нь мэдээж цэвэр цэргийнхээс ялгаатай, бөмбөг дэлбэрч, танкийн гинж тачигнаж, хүний амь шууд эрсдэхгүй хялбар мэт санагдаж болох ч үүнээс болоод түүний ач холбогдол бага байгаагүйг энд хэлэх юун. Цэргийн дипломатыг өөртөө багтаасан “их” дипломат нь нийтийн дайсныг бут цохих эцсийн зорилгод цэргийн стратегитэй зорилго чиглэл нэг байж бие биеэ нөхөн “бүхэл цул, иж бүтэн” ялагдашгүй хүчин болж байсны нэгэн жишээ нь Ялтын бага хурал, түүний дараах холбоотон гүрнүүдийн нэг бус театрт амжилттай явуулсан цэргийн стратегийн хамтын ажиллагаа юм. Үүнийг одоо цагт ч ач холбогдлоо алдаагүй сургамжтай, харин нэр төрөл, цэргийн ажиллагааны хувьд маш боловсронгуй болсор буй зүйлийн нэг гэж ойлгож байна.

Юун гэвэл, орчин цагийн геополитик, геостратегийн ерөнхий дүр зураг, тэрчлэн бидэнд хамаагүй мэт боловч хааяа гэнэт, хурц өнгө аястай гарсаар буй гүн хямрал, зэвсэгт мөргөлдөөн, ялангуяа олон улсын терроризм хийгээд уламжлалт бус зарим заналтай бүх нийтээр явуулж буй глобал тэмцлийн шинж байдлыг “жирийн нүдээр” харсан ч үндэсний хийгээд олон улсын аюулгүй байдлыг хангах стратегид дипломат ба цэргийн хүчин хуучных шигээ “нэг мөнгөний хоёр тал” байдаггүй юмаа гэхэд нэлээддээ цэргийн хангалт, нөөцтэй байхыг шаардах бололтой мэт. Хэнд, хаана гэдэг нь мэдээж өөр асуудал.

2. 1945 оны эхээрх буюу бага хурлын өмнөх цэрэг-улс төрийн байдлын онцлог гэвэл нэгдүгээрт, фашизмын эсрэг эвсэл эрс өргөжиж,

үндэсний чөлөөлөх хөдөлгөөн өрнөсөн, хоёрдугаарт, фашизмын эсрэг эвсэл, цэргийн холбоотон орнуудын цэргийн хэлхээ холбоо, стратегийн зорилт, түүний хэрэгжүүлэх удирдлага төлөвлөлт, үйл ажиллагаа харьцангуй нягтарч, цэргийн байлдааны ажиллагааны бараг бүх театрт стратегийн санаачлагыг бүрэн гартаа авсан /Европын дайны талбарт/ ЗХУ, түүний зэвсэгт хүчин стратегийн давуутай байдлыг эзэмшсэнээр “энэ үед зэвсэгт хүчний нь байлдааны хүч чадал дайны жилүүдэд хамгийн дээд хэмжээнд байв” өөрийн улсын бараг бүх нутаг дэвсгэрийг чөлөөлсөн. Мөн Гитлерийн эсрэг эвслийн зэвсэгт хүчний давшилтын үрээр Европын олонх орны нутгийг дайснаас чөлөөлж, байлдааны ажиллагааг Германы газар нутагт шилжүүлсэн, гуравдугаарт, өрнөдийн холбоотон гүрнүүд Европ, Африк, Номхон далайд цэргийн ажиллагаагаа идэвжүүлэхийн зэрэгцээ Европт хоёрдугаар фронт нээсэн, дөрөвдүгээрт, 1944 оны сүүлчээр Европт фашист эвсэл задарсан, фашистын герман гадаад бодлогын хувьд ганцаардалд унаж, дотоод улс төр, цэргийн байдал хүндэрсэнийг дурьдахад хангалттай. Өөрөөр хэлбэл, дэлхий дахины бага хурлын өмнөх цэрэг-улс төрийн байдал нь эрх чөлөөг эрхэмлэгч улс түмэн, фашизмын эсрэг эвсэл, хөдөлгөөний хувьд элдэв зөрчил тэмцэлгүй биш ч ихээхэн ашигтай өөрчлөгдсөнөөр хэрэг дээрээ Гитлерийн ялагдал гарцаагүй болохыг сануулж харуулсаар байжээ. Гэвч энэ нь Европт дайн хялбар төгсөх нөхцөл бүрдсэн үг биш бөгөөд хэдийгээр фашист эвслийн цэрэг-улс төрийн байдал муудсаар байсан ч эрх баригчид нь дайныг сунжруулах, бүрмөсөн ялагдахгүй байхад чиглэсэн арга хэмжээг авсаар, хаа нэгтэй дэмжлэг олоход найдахтайгаа байв. Түүхийн олон ном дурьдатгалаас үзэхэд 1944 оны 8 дугаар сард гэхэд Зөвлөлтийн армийн эсрэг 288 дивиз, 23 бригад /хоёрдугаар дайны гол фронт/, холбоотнуудын эсрэг 87 дивиз байсан ажээ. Энэ нь бага хурлын үеэр ч фашистын Герман хүчтэй дайсан хэвээр, шавхан дайчлах эцсийн нөөц нь барагдаагүй байсныг гэрчилдэг. Мөн түүний цорын ганц түнш Японы Зүүн Өмнөд Ази дахь байр суурь суларсан ч, ялангуяа хуурай замын цэргийн стратегийн 4 бүлэглэл нь байлдах чадвараа халгалсаар Хятадал гэхэд зарим амжилт олсоор байв.

Ийм нөхцөлд Ялтын бага хурлыг санаачлан хуралдуулж дайны үеийн болон түүний дараах дэлхийн улс төрийн бодлого, геостратегийн ач холбогдол бүхий томоохон асуудлуудыг зөвшин шийдвэрлэсэн нь түүхэн ач холбогдолтой болсон юм.

3. ЗХУ Японы эсрэг дайнд орохын өмнөх дипломатын ба цэргийн ажиллагаа бол өнөө хэр чухал судлагдахуун, маш сонирхолтой асуудал гэж бодож байна. Тус бага хурал Алс Дорнодын асуудлаар багахан цаг зарцуулсан, тунхаглалд нь энэ бүс нутгийн нэр ч дурьдагдаагүй аж. Эндээс дэлхийн 2-р дайны дараах Европын хувь заяаны талаарх хурц ширүүн маргааны ард Японтой хийх дайны төлвийг тодорхойлох тулгамдсан хэрэгцээ /цаг хугацааны талаас ч гэсэн/ нуугдмал янзтай байжээ гэж үзэхээр байгаа юм. Ер нь бол 1945 оны 2 дугаар сард Европын дайны эцэс тодорхой болсон тухай дээр хэлсэн. Харин Барууны холбоотнуудын хувьд Номхон далайн арлуудад ялалт байгуулсаар байсан ч бүхэлдээ дайны театр дахь эцсийн зорилго, цэргийн ажиллагааны үргэлжлэл, төгсгөл нь бэрхшээл ихтэй, бүрхэгдүү /АНУ-ын штабын дарга нарын нэгдсэн хорооны дарга Дж.Маршаллын хэлснээр бол зөвхөн Японы нутагт цэргийн ажиллагаа явуулахад нэг саяас багагүй цэрэг шаардлагатай, харин Америкийн командлалын тооцсоноор энэ нь дайныг 1947 оноос өмнө дуусгах бололцоогүйд хүргэх байжээ/, Японы тал хуурай замын цэргийн тоо, зэвсэглэлээр давуутай, өөрийн нутагт болон Манжуурт сунжирмал дайн явуулахад бэлтгэж байсан зэргээс болж Японы эсрэг дайнд ЗХУ-ыг оролцуулах хэрэгцээ тэдэнд онцгой их байсан нь ойлгомжтой.

1943 оны Тегераны бага хурлын үеэр ЗХУ, Германыг бут цохисны дараа Японы эсрэг дайнд оролцохоо амласан болохоос хугацаа, болзол нөхцлийг нь тогтоогоогүйг бид мэднэ. Иймээс энэхүү нөхцөл болзлын талаар 1944 оны сүүлчээс улам ил шургуу явагдсан дипломатын болон бусад элдэв явуулга чухамхүү Ялтын бага хурлын гол агуулга болж асуудал оргилдоо хүрч, тэр нь Сталины “нутаг дэвсгэрийн болон Азийн шаардлага” гэгчтэй хамтдаа шийдэгдсэн түүхтэй.

Тус бага хурлын явц, үр дагаврын тухайд гэвэл мэдээж дайн, цэрэг-стратегийн асуудлыг тухайлбал, фашист Герман, милитарист Японтой хийж буй дайныг ялгууснаар дуусгах эрх ашигт чиглэгдэхийн зэрэгцээ дайны дараах дэлхий дахины төвхнөлд гол анхаарлаа хандуулснаараа онцгой ач холбогдолтой болсон байдаг. Харин сүүлчийн асуудлын шийдлийн талаар бол хоёр өөр буюу эцэстээ “хүйтэн дайны” цэрэг-улс төрийн нөхцөл байдлын урьтал гэхээр сөрөг хандлага илрэн гарч байсан болох нь эдүгээ ойлгомжтой болжээ. Гэвч энэ нь тухайн цагт Холбоотон гурван гүрэн ээдрээ зөрчил бүхий нарийн төвөгтэй хэд хэдэн чухал асуудлаар тодорхой шийдвэр гаргаж, түүнийг нь эрх чөлөөг эрхэмлэгч

бүх улс түмэн үндсэндээ сайшаан хүлээн авсаныг үгүйсгэх үндэс болж чадахгүй нь мэдээж.

ЗХУ Европт дайн дууссанаас хойш 3 сарын дараа Японы түрэмгийлэгчдийн эсрэг дайнд орохоо тус бага хурлын үеэр мэдэгдэн нотолж, улмаар Европт дайныг дуусгаснаас хойш богино хугацааны дотор бүх бэлтгэлийг найдвартай хангаснаар 1945 оны 8 дугаар сарын 8-ны шөнө давшилтаа эхэлж 9 дүгээр сарын 2-нд Япон бууж өгсөнөөр холбоотон гүрнүүд Дэлхийн хоёрдугаар дайныг гарамгай ялалтаар төгсгөсөн билээ. Эцэст нь Монголын Ардын Хувьсгалт цэрэг хоёр талын тохиролцсоны дагуу Өвөр Байгалийн командлалд опертивын хувьд захирагдаж Зөвлөлт-Монголын цэргийн морьт механикжуулсан бүлгийн бүрэлдэхүүнд орж байлдааны цагийн үүргээ нэр төртэй биелүүлж нийтийн үйлст хувь нэмрээ оруулан бахдам гавьяа байгуулсаныг тэмдэглэхийг хүсч байна.